



**ХЭНТИЙ АЙМГИЙН
МӨРӨН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН
ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ**

2025 оны 05 сарын 01 өдөр

Дугаар А/17

Мөрөн сум

**Хог пресслэгч машин хүлээн авах
комисс байгуулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Сумын Засаг даргын 2025 оны 3 дугаар сарын 24-ний өдрийн А/47 тоот захирамжаар байгуулагдсан Сумын үнэлгээний хорооны 2025 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийн 02 тоот зөвлөмжийг тус тус үндэслэн Тушаах нь:

1.Борхоодой Трейд -ХХК нь сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хөрөнгө оруулалтаар Хог пресслэгч машин худалдан авах ажлын тендерт ялж 2025 оны 04 сарын 01-эс 2025 оны 05 дугаар сарын 01-ний дотор нийлүүлэх гэрээ байгуулсан тул уг ажлын хүлээн авах комиссыг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Комиссын дарга:	Г.Загдхорол Хөдөлмөр Халамж Эрхлэлтийн асуудал хариуцсан мэргэжилтэн	
Гишүүд:	Б.Бямбадорж	Байгаль хамгаалагч
	Ж.Алтанцэцэг	Татварын улсын байцаагч
	Э.Балчиндорж	Цагаан толгой багийн Засаг дарга
	А.Энхтөр	Аж ахуйн нярав

2.Борхоолдой Трейд ХХК-аас хүлээн авах Хог пресслэгч машины ажлыг гэрээний хавсралт болох техникийн тодорхойлолтыг үндэслэн тоо ширхэг , хүчин чадал, чанар байдлыг нэг бүрчлэн шалгаж, фото зургаар баримтжуулан акт үйлдэж хүлээн авахыг комиссын дарга (Загдхорол)-д үүрэг болгосугай.

3.Хог пресслэгч машиныг Засаг даргын Тамгын газрын үндсэн хөрөнгөнд бүртгэж авахыг Нягтлан бодогч (Б.Нандин-Эрдэнэ)-д даалгасугай.

ДАРГА

Н.НАМЖИЛНОРОВ